



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/26

Баян-Адарга

Г

Г

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Дуурлиг багийн "Хогийн цэгийг хашаажуулах" худалдан авах ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---------|--------------|----------------------------------|
| Ахлагч: | Н.Ганбат | (Засаг даргын Орлогч дарга) |
| Гишүүд | М.Нямдорж | (Дуурлиг багийн Засаг дарга) |
| | С.Пүрэвцэрэн | (Төсвийн ерөнхий Нягтлан бодогч) |

2.Худалдан авах ажиллагааны холбогдох хууль тогтоомж, ажлын техникийн тодорхойлолт, гэрээний дагуу хүлээн авч, танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Ганбат)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Бат-эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.ЛХАГВАДОРЖ